



**МОНГОЛЫН ТУСГААР ТОГТНОЛ
БА МОНГОЛЧУУД**

Эмхэтгэсэн С.ЧУЛУУН

XX ЗУУНЫ ЭХЭН ҮЕИЙН МОНГОЛЫН “ИХ ХҮРЭЭ”-НИЙ ЗУРГУУДАД ХИЙСЭН ШИНЖИЛГЭЭ

Телеки Кристина

Монгол улсын нийслэлийн түүхийг судлахад монгол, төвд судар ном, архивын сурвалж бичгүүд, гадаадын жуулчдын монгол нутгаар аяласан тухай тэмдэглэл, өндөр настай лам нарын дурсамж зэргээс гадна онцлог баримтуудын нэг нь тухайн үеийн зурмал болон гэрэл зургууд чухал үнэт баримт болж өгдөг. Нийслэл хүрээний талаар судлахад гадаад дотоодын хүмүүсийн үлдээсэн зургуудыг нэгэн цогц болговоос ихээхэн ач холбогдолтой юм. Учир нь зурсан зураг, гэрэл зургуудыг газрын зураг шиг хэрэглэх болдог боловч түүн дээр тэмдэглэгдсэн сүм дугануудын хэв маяг, хүмүүсийн амьдрал зэргийг тодорхой мэдэж болдогоороо давуу талтай.

Энэ илтгэлийн эхний хэсэгт хүрээг зурсан монгол зураачдын зургууд, дараагийн хэсэгт нь гадаадын жуулчдын авсан гэрэл зургуудыг танилцуулах болно.¹

1911 онд Богд хаант монгол улсыг байгуулж, нийслэл хотоо Нийслэл хүрээ хэмээн нэрлэсэн байдаг. Энэхүү нийслэл хүрээг зурсан зургуудаас Жүгдэрийн зурсан зураг (50x95) хамгийн дэлгэрэнгүй нь юм. Жүгдэр нь Хүрээний 30 аймгийн нэг Зоогийн аймгийн Гэндэндамба агаарамбын шавь бөгөөд Богд хааны зарлигаар 1913 онд зургаа бүтээжээ. Одоо Богд хааны ордон музейд хадгалагддаг. Энэ зурган дээр тухайн үеийн шарын шашны гол төвүүд болох Зүүн хүрээ, Гандан хоёрыг нилээд дэлгэрэнгүй зурсан хэдий ч хятадын худалдаачдын сууж байсан газруудыг тойм төдий зурсан байдаг.

Улаанбаатар хотын музейд хадгалагдаж байгаа Манибадарын зурсан том хэмжээтэй зураг мөн адил Хүрээг дэлгэрэнгүй харуулсан.

Жүгдэрийн зурагнаас түрүү үеийн зургуудаас сонирхуулвал:

Занабазарын нэрэмжит Дүрслэх Урлагийн музейд Балганы зурсан зураг (130x140) бий. Хүрээний Сэцэн тойны аймгийн лам байсан 1880-аад онд энэхүү зургаа зуржээ. Улаанбаатар хотын музейд хадгалагдан буй нэлээд төстэй зурагдсан зургийг монголчууд энэ зургийн анхны хувь нь гэж үздэг. Энэ зураг дээр 129 тооны шашны сүм хийдүүд болон энгийн газрыг тэмдэглэсэн байдаг. Мөн сүм хийдүүдийн байшингаас гадна хүмүүсийн амьдрал тэр тусмаа лам нарын ёс жаягыг дэлгэрэнгүй харагддаг.

Хятадын худалдаачдын суурин, тариалангийн газруудтай холбоотой зурсан зургуудын нэг нь 19-р зууны сүүл үеийнх бололтой Хүрээг тойм харуулсан ч хятад иргэдийн сууринг нарийн харуулсан зураг бидэнд олдсон.

Монголын Үндэсний Номын Санд хадгалагдаж байгаа хоёр газрын зураг хоорондоо бараг адилхан (341/96, 368/96). Нэг нь Дотоод Яамны хөрөнгө гэж тэмдэглэгдсэн 1920-иод оны орчим зурагдсан. Уг зурган дээр хүмүүсийг огт зураагүй боловч сүм дуган, хүрээний аймгууд, хороо, харчуудын гудамж, орос, хятад худалдаачдын пүүс байшингуудыг нарийн тэмдэглэсэн.

Цүлтэмийн “Монголын зураг” хэмээх номонд орсон Хүрээний 19-р зууны үед зурагдсан зураг ихээхэн сонирхол татдаг. Учир нь энэ зураг дээр Зүүн хүрээ Гандангаас баруун зүгт зурагдсан байдаг. Хүрээ нь 1839-1855 оны

¹ Уг судалгааг Унгар улсын ОТКА PD 83465 ивээн тэтгэсэн.

хооронд Толгойтод түр байрлаж байсныг харуулсан бололтой. Үүнээс үзвэл 1838 оноос хойш, мөн зөвхөн 27 аймгийг зурсан нь 1877 оноос өмнө зурагдсан байх магадлалтай.

Ямар нэгэн зургийн он сар мэдэгдэхгүй тохиолдолд оныг тогтоох зарим нэгэн арга байдаг. Жишээлбэл: Гандантэгчэнлин дуган 1838 онд баригдсан. 30 аймгийн хамгийн сүүлд баригдсан гурвын он тодорхой байдаг. Мэргэн хамбын аймгаас тасалж байгуулсан Чойнхорлин аймаг 1877 он, Махамаягын аймгаас тасалсан Дашдандарлин аймаг 1892 он, хамгийн сүүлд бий болсон Эх дагинын аймаг 1903 он, Жанрайсэгийн сүм ба Идгаачойнзинлин дацан 1911 онд тус тус баригдсан байдаг.

Хүрээний бусад гурван зураг Богд хааны ордон музейн сан хөмрөгт хадгалагдаж байна. Эдгээрийн нэг нь хүрээний цамыг, бусад нь хүрээний хэсгүүдийг харуулжээ.

Нэг нэг байшин болон чухал баяр ёслолыг харуулах зургуудын жишээ нь: Богдыг залах зам, Өвлийн ордон, Хайстай лавран гэх мэт.

1938 оны хэлмэгдүүлэлтийн дараа зурсан зургууд байдгаас Дамдинсүрэнгийн "Хүрээ цам", Дунбүрээ болон бусад алдартай зураачдын зургуудыг нэрлэж болно.

Дээр дурдагдсан албан байгууллагуудын сан хөмрөгт буй зургуудаас гадна хувь хүмүүсийн сан хөмрөгт ч байна. Пүрэвбат ламын танилцуулсан зураг, Бадамхандын зургийн цомирлогоос гадна гадаадын судлаач эрдэмтэдийн хувийн хөмрөгт ч сонирхолтой зургууд хадгалагдан байна. Жишээ нь:

Ричард Эрнст-ийн хувийн хөмрөгт хадгалагдаж буй зураг дээр Ганданг тойроод 27 аймаг харагдаж байна. Аймгийн дуган мэдээж Ганданд байгаагүйг энд ч бас тэмдэглэжээ. 27 лам нарын зарим нь мяндаг тушаалтай. Суврага, байшингуудын хэв маяг нилээд сонирхолтой. Ричард Эрнст (Richard Ernst) Швейцар улсын химийн новелийн шагналтны авсан судалгааны дээжээс харсан ч энэ зураг нь 19-р зууны дунд үеийнх болох нь батлагддаг.

Хүрээний талаар одоогоор олдсон зургуудыг дүгнэж үзвэл 19-р зуунаас зурагдаж эхэлсэн нь тодорхой байхаас гадна бүгд сүм хийдүүд, хүрээний амьдрал, лам нарын ёс жаяг зэргийг дэлгэрэнгүй харуулж байгаа нь цаашдаа тус тусд нь нарийвчлан судалваас зохилтой хэмээн бодож байна.

Гадаадын хүмүүсийн зургуудыг үзэхэд бараг бүгд гэрэл зургууд байдаг. 19-р зууны 2-р хагасаас эхэлж Монголд ирсэн гадаадын жуулчид гэрэл зургийг түлхүү авсан. Гэрэл зургуудын зарим нь ном зохиолд орж байсан. Жишээ нь: Н. М. Шепетилников,² Д. Майдар,³ Н. Цүлтэм,⁴ Ө. Сэрээтэр⁵ гэх мэтийн зохиолчдын номонд орсноос гадна энэ жил бүтээгдсэн "Монголчууд" хэмээх номонд ч нилээдгүй орсон. Гэвч эдгээрийн ихэнх зургийг хэн, хэзээ авсан, зурган дээр чухам юу харагдаж байгааг анзаарахгүйгээр зохиол бүтээлдээ сүүлийн үеийн зарим зохиолчид ашиглаж байна.

Монгол улсын Кино гэрэл зураг, дуу авианы баримтын архивд шашинтай

2 Шепетилников, Н. М., *Архитектура Монголы*. Москва 1960

3 Майдар, Д., *Монголын архитектуру ба хот байгуулалт*. Улаанбаатар 1972

4 Цүлтэм, Н., *Монголын уран барилга*. Улаанбаатар 1988

5 Сэрээтэр, Ө., *Монголын Их хүрээ, Гандан хийдийн түүхэн бүтэцийн товч 1651-1938*. Улаанбаатар 1999

холбоот
хүрээ, Д
ордон, Га
шашны т
Академи
зургийн
Мон
монгол
байна. Ж
үед үнэ
дурдагд
гадна хэ
авсан уч
байна. Га
тодорхой
үнэ цэнэ
дотоодын
Гэрэл зур
авсан бай
байсан б
зургууд н
миний та
Орос
монгол су
нь мэддэг
хийдүүди
монгол хэ
аялалын т
нэгэн зур
бүтээлүүд
Монг
ирдэг бай
өнгөрдөг
танин мэд
ирдэг бай
байсантай
хийх, ша
дараа Сиб
янз бүрий
аль эсвэл
монголчу
буцан оч
зүйлүүдий
үнэн бод
Одоо
зэргэлдээ
Пржевалск

холбоотой 5-6 хайрцаг хуучны зураг хадгалагдаж байна. Хүрээний тухай Да хүрээ, Дамбадаржаалин хийд, Чойжин ламын сүм, хятад сүм дуганууд, Шар ордон, Гандантэгчэнлин хийд, Майдар эргэх, Цам харайх болон бусад баярууд, шашны тэргүүн нарын зургууд байна. Мөн Монгол улсын Шинжлэх Ухааны Академийн фото зургийн сан хөмрөгт хүрээний талаарх янз бүрийн хэмжээтэй зургийн альбомууд хадгалагдан байна.

Монголын Үндэсний Түүхийн Музейн сан хөмрөгт 1910-аад оны үед монгол нутгаар аяласан Черүшингийн авсан хэдхэн гэрэл зураг хадгалагдаж байна. Жишээ нь: Тухайн үеийн Шаддүвлингийн зургийг авч үлдээсэн нь өнөө үед үнэ цэнэтэй зургуудын тоонд зүй ёсоор орох бүтээл болж чадсан. Энэхүү дурдагдаж буй гурван сан хөмрөгийн зургуудын тайлбар учир дутагдалтайгаас гадна хэн, хэзээ авсан нь тодорхойгүй. Эдгээр зургуудыг гадаадын жуулчид авсан учир эх хувь болон хуулбарууд нь тухайн улсад болон монгол улсад байна. Гадаадын сан хөмрөгт буй зургуудыг хэн, хэзээ авсан талаарх мэдээлэл тодорхой байгаа хэдий ч яг ямар нэртэй газар, сүм дуган, хүмүүсийн зураг, ямар үнэ цэнэтэй түүхийн баримт болохыг ажиллагсад нь мэддэггүй. Иймээс гадаад дотоодын судлаач нар хамтран ажиллавал илүү үр дүнд хүрнэ гэж бодож байна. Гэрэл зургуудыг үзэхэд 19-20 зууны орчим монгол нутгаар дайран өнгөрөхдөө авсан байна. Нийслэл хүрээний сүм дуганууд 1938 оны хүртэл хуучин хэвээр байсан боловч монголын түүхэнд тохиолдсон их хэлмэгдүүлэлтийн дараах зургууд нь орчин цагийн Улаанбаатарын дүр төрхийг харуулсан байдаг нь миний тавьж буй энэ сэдэвт хамаагүй юм.

Оросын алдарт эрдэмтэн А. М. Позднеевийг (Монголд 1876, 1892-93 он) монгол судлаачид болон монголчууд монгол судлалд оруулсан их хувь нэмрээр нь мэддэг билээ. Тэрээр монголын бурхны шашин, Их хүрээ, хөдөөний сүм хийдүүдийн тухай нэлээд дэлгэрэнгүй судласан. Түүний номуудаас одоо хүртэл монгол хэлэнд орчуулагдан гараагүй байна. Гэвч товчхон харсан үзсэнэ бичсэн аялалын тэмдэглэлүүд сүүлийн үед их гарах болжээ. Тухайн бүтээлүүдэд зарим нэгэн зургууд тавигдсан нь хэдий ч гадаадын монголч эрдэмтэдийн судалгааны бүтээлүүдийг орчуулбал их ач холбогдолтой байхаар байна.

Монгол нутагт жуулчид өөр өөр улсаас янз бүрийн зорилгоор хүрэлцэн ирдэг байлаа. Зарим нэг нь Хиагт Хаалган хот хооронд зорчихдоо дамжин өнгөрдөг байсан. Зарим нэг нь тухайн цаг үед танигдаагүй байсан улсуудыг танин мэдэх цаашлаад дэлхийд таниулах зорилгоор газар зүйн судлаач нар ирдэг байжээ. Учир нь тухайн үед Европчууд дэлхийн олон нээлтүүдийг хийж байсантай холбож болмоор байна. Өөр бусад соёлтой танилцах, худалдаа наймаа хийх, шашны зорилгоор ч ирж байсан байдаг. Мөн дэлхийн 1-р дайн дууссаны дараа Сибирийн цөллөгөөс нутаг руугаа буцаж буй хүмүүс ч байлаа. Хэдийгээр янз бүрийн санаа зорилгоор ирж байсан ч Монголд зарим нь хэдхэн хоногоор, аль эсвэл хэдэн жилээр зарим нь он удаан жилээр сууж байжээ. Тэдгээр хүмүүс монголчуудын тухай дэлхий нийтэд мэдүүлэгч нар байсан. Энэ талаар нутагтаа буцан очиж аян замын тэмдэглэл, өгүүлэг, авсан зургууд, авч явсан эд өлгийн зүйлүүдийг бусдад таниулж байсан. Монгол улсын 100 жилийн өмнөх түүхэн үнэн бодит баримтыг гэрэл зурагт мөнхлөн үлдээж бидний үед ирсэн.

Одоо та бүхэнд зарим нэгэн судлаачдын тухай танилцуулая. Хөрш зэргэлдээ улс болох Оросоос хамгийн олон судлаачид байна. Жишээ нь: Н. М. Пржевалский (1870-73), Г. Потанин (1870-аад он), А. М. Позднеев (1876, 1892-

93), П. К. Козлов (1905, 1907-1909, 1923-1926), Н. Рерих (1900- оод он), Ш. А. Кондратев (1920-оод он), А. Д. Симуков (1930-аад он). Эдгээр хүмүүсээс гадна Орос консулын ажилчид, эгэл энгийн ардууд ч амьдарч байлаа. Оросуудын авсан гэрэл зургуудын ихэнх нь 1845 онд Санкт-Петербург хотод баригдсан Оросын Газар зүйн нийгэмлэгийн архивт хадгалагддаг. Үүнээс гадна зарим нэг судлаачийн тусдаа музей ч байна. Жишээлбэл: Н. Рерих, П. К. Козлов.

Хойт Европоос 20-р зууны эхээр Финляндийн хэл шинэжлэлийн эрдэмтэн Gustav John Ramstedt (1898, 1909, 1912) болон түүний зурагчин Sakari Pälsi нар судалгааны ажлаар ирж байжээ. Мөн саяхан монгол хэлэнд Шведийн иргэн Larson-гийн (1895-1910-аад он) бичсэн ном хэвлэгдсэн. Дани улсын Henning Haslund-Christensen-гийн (1923) авсан зургуудыг сүүлийн үед интернетэд тавигдсан байхаас гадна олон ном зохиолуудад хэвлэгдсэн. Английн жуулчдын James Gilmour (1890-өөд он), Beatrix Bulstrode (1910-аад он), G. C. Binsteed-ийн (1910-аад он) авсан зургууд Лондонгийн Газар зүйн нийгэмлэгийн архивт хадгалж байгаа болов уу.

Францын Albert Kahn ба Stefan Passe нарын 1910-аад оны эхээр авсан гэрэл зургууд нь анхны өнгөтөөр авсан гэрэл зургууд мөн юм. Энэхүү гэрэл зургуудыг Albert Kahn-ы музей 2012 онд дэлгэн үзүүлэх болно. Madame de Bourbolon-гийн авсан сүм хийдүүдийн зургийг (1880 он) мөн адил монгол хүмүүст танил билээ. Германаас Hermann Consten (1907, 1911, 1928-1929) хэмээх хүн нилээдгүй зураг авсан байдаг.

Америкийн жуулчин Roy Chapman Andrews (1921-1930) болон Япончуудын авсан гэрэл зургууд олдож буй хэдий ч харин Хятадууд Хүрээнд хэдэн зуугаараа амьдарч байсан боловч тэдгээрийн авсан гэрэл зургуудыг одоо болтол олж үзсэнгүй. Хүрээнд олон улсаас хүмүүс ирж байсныг тэр болгон тэмдэглэж байгаагүй учир бидэнд мэдэгдээгүй өөр бусад хүмүүсийн авсан зургууд олдох боломжтой.

Тухайлбал манай Мажар улсын иргэд болох Geleta Jyzsef, Radnyti-Ryth Andor (1893-1964) нар 1920-иод оны эхээр Сибирийн цөллөгөөс буцах замдаа Хүрээнд түр зуур оршин суусан байдаг. Radnyti Монголд эмчээр ажиллажээ. Radnyti 1920-иод онд ((1922 оны 4 сарын 1.) Хүрээнд зураг авахад тусгай зөвшөөрөл авжээ.⁶ Түүний авсан 66 гаруй гэрэл зураг Унгарын Үндэсний Музейд хадгалагдаж байна. Эдгээр шашин, улс төр, аж амьдралтай холбогдох гэрэл зургуудын дотор Жалханз хутагт Дамдинбазар, Хичээнгүй сайд Цэрэндорж гэх мэтийн түүхт хүмүүс, хүрээний зарим сүм дуган, Богдын ордонууд, хөдөөний эгэл ардуудын амьдралын зургууд бий. Уг 66 зургын тайлбар нь:

⁶ Kara, Gy., Mongol iratok a Népi Forradalom idejéből. Budapest 1971, 2-p x

шашин: 3
69.110
69.112
69.125
69.123
69.184
69.113
69.114
69.115
69.188
69.106
69.195
69.121
69.109
69.181
69.194
69.116
69.117
69.118
69.187
69.211
69.182
69.192
69.207
69.208
69.209
69.124
69.210
69.122
69.180
69.222
улс төр:
69.120
69.107
68.533
69.223
69.127
69.197
69.201
69.202
69.203
69.204
69.205
69.206
69.213

шашин: 30 зураг

- 69.110 Голын ногоон сүм
- 69.112 Богдын сүйх тэрэг
- 69.125 Сэтэртэй морь, тэнгэрийн хүлэг
- 69.123 Богд хаан, Эх дагина хоёрын сэнтий шавдан
- 69.184 Богдын Цагаан сүм
- 69.113 Богдын Цагаан сүм
- 69.114 Богдын Цагаан сүмийн гол дуган
- 69.115 Богдын Цагаан сүм
- 69.188 Богдын Сэрүүн лавран
- 69.106 Богдын Сэрүүн лавран
- 69.195 Чойжин ламын сүм
- 69.121 Занданшуулсан дүр
- 69.109 Бурханы өмнө тахил зул
- 69.181 Сүмийн дотор Бурхан багш шавь нартайгаа
- 69.194 Майдарын сүм
- 69.116 Дуганы өмнө
- 69.117 Дуганы өмнө
- 69.118 Том балингууд
- 69.187 Гандантэгчэнлин хийдийн Жанрайсэгийн дацан
- 69.211 Суврага
- 69.182 Сүмийн их бойпор
- 69.192 Шургадаг суврага
- 69.207 Майдар эргэх
- 69.208 Майдар эргэх
- 69.209 Майдар эргэх (Сэлбийн гүүр)
- 69.124 Богд Зонхов
- 69.210 Хөдөөний бурхны шашны хийд
- 69.122 Хөдөөний жижиг хийд
- 69.180 Зоч ламын цацар
- 69.222 Шашны зан үйл

улс төр: 15 зураг

- 69.120 Хичээнгүй сайд Цэрэндорж
- 69.107 Хичээнгүй сайд Цэрэндорж ард түмнийхээ дунд
- 68.533 Ардын журамт цэрэг
- 69.223 Жалханз хутагт Дамдинбазар
- 69.127 Оросын консул, Жалханз хутагт Дамдинбазар хоёр
- 69.197 Улаан армийн цэргийн дарга нар ба монгол цэргийн удирдагчид
- 69.201 Орос цэргийн дарга нар ба монгол удирдагч нар
- 69.202 Улаан цэргийн ёслолоо
- 69.203 Орос цэргийн дарга нар ба монгол удирдагч нар
- 69.204 Залуучуудын цуглаан
- 69.205 Монгол орос хүмүүсийн цуглаан
- 69.206 Монголын хувьсгалт залуучуудын цуглаан (бошгийг халах
залуучуудын эвлэлийн цуглаан)
- 69.213 Орос цэргийн дарга нар ба монгол удирдагч нар

- 69.191 Ялтан хорих гяндан
69.221 Монгол ардын журамт цэргийн жагсаал

аж амьдрал: 21 зураг

- 69.186 Хүрээний хар зах
69.189 Хүрээний хар зах
69.190 Хүрээний хар зах
69.111 Түлшний зах
69.126 Монгол ардын өндөр хоршоо үйрийн үед
69.183 Хүрээ үйрийн үед
69.215 Хүрээний соёлтой эр хүн
69.193 Хятад худалдаачин тооно ба торх зарж байгаа
69.219 Морны наадамд очсон наадамчид
69.119 Хурдан морны хүүхэд
69.196 Монгол наадмын сур харваа
69.220 Байгалийн зураг
69.198 Нэмнээтэй ботго
69.199 Өвлийн дээл өмссөн монгол банди
69.212 Хуурчин
69.214 Хөдөөний лам
69.108 Малчин эмэгтэй
69.216 Малчин айл
69.218 Малчин айл
69.217 Малчин эмгэн
69.185 Хунгараас машинийг гаргаж байгаа

Эцэст нь дүгнэж хэлбэл Улаанбаатар буй Кино гэрэл зураг, дуу авианы баримтын архив, Шинжлэх Ухааны Академи зэрэг албан газруудад байгаа зургуудын дотор А. М. Позднеев, П. К. Козлов, Ш. А. Кондратов, А. Д. Симуков зэрэг хүмүүсийн авсан зураг байгаа. Үүнээс гадна бусад олон зургуудыг хэн, хэдийд авсныг тогтоох нь чухал байна. Мөн гадаадын сан хөмрөгт хадгалагдаж буй зургуудийн тайлбар бичиж, хуулбарлах эс бөгөөс ном хэвлэлтэнд гаргавал эрдэмтэн судлаач, олон нийтэд их тустайгаас ажил болох юм.



